


АЖ ТӨРӨХ
УХААН

Г.Ловор

ХОТ АЙЛ



II
ангийнханд
зориулав

**Г.Ловор
Хот айл**

Бага сургуулийн 2-р ангийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах
Хянан тохиолдуулагч	Д.Сугархүү
Хянагч	О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Ж.Гэрэлмаа
	Н.Хөдөлмөр
	Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпрес ХХК

2007 он


Хот айл

- Өвөө, "Улаанбаатар шиг том хот монголд байхгүй" гэж манай багш хэлсэн. Гэтэл энэ номд хот айл гэж бичсэн байх юм?



- Тийм ээ, тэр чинь байшин барилгатай хотыг хэлж байгаа юм биш. Хөдөөд хэд хэдэн гэр айлсаж буухыг хот айл гэж нэрлэж байгаа юм гэхэд ач нь ихэд гайхан,

- Гэрүүд байхад яагаад хот айл гэдэг юм бэ?
- Энэ учиртай. Хот айлын баруун урд талых аавынх, зүүн урд талых нэр хүндтэй ахмад настных.



Ар талд хөвгүүд нь буух жишээтэй байрлаж, гэрүүдийн хооронд хонь ямаа, бог малаа хотлуулж, тэрэг тоног, аргал түлээ нь захаараа хүрзэлсэн маягтай буудаг.

- Сургууль нь хаанаа байдаг юм бэ?
- Сургууль нь сумынхаа төв дээр. Өглөө бүр хүүхдүүд мориор хичээлдээ явдаг.



- Ямар сайхан юм бэ?
- Өдөр болгон сургуульд мориор явах ч тийм амар ажил биш дээ.
- Энэ номд "хонинь хишиг" гэж бичсэн байна. Юу гэсэн уг вэ?
 - Хот айлынхан хонь малаа ээлжилж хариулдаг. Түүнийг хэлж байгаа юм. Ер нь гурав дөрвөн айл хотолж буусан гэхэд ажлаа чиний миний гэхгүй хамтарч хийнэ.

Тал хээрийн нутагт бол адуугаа ч хамт усална. Оройдоо үхрээ дөхүүлж хотлуулна. Малаа ноослох, эсгий хийх, хашаа хороогоо засах, нүүж суух болоход цөм элбэлцэнэ.



Тэгээд ч “айл хүний амь нэг” гэдэг үгтэй юм даа гэж тайлбарлавал ач нь бас л номд гардаг “хүрээ хот” гэсэн үгийн учрыг асуулаа.

- Хот айлын хамгийн гадна талд морины уяа, чингэлэг, мухлаг тэрэг, үхэр тугалын хашаа, гэрийн ойр араг савар, төл малын пүнз гэх мэт нь байна. Үns хогоо эмх цэгцтэй хотноос зайдуу, гал түймрээс сээрэмжилж асгана.

Ингэж эрт дээр цагаас нүүдэлчид хүрээлэн буудаг байснаас хүрээ хот гэж нэрлэгдэж ирсэн. Ардын хувьсалаас өмнө Улаанбаатарыг "Нийслэл хүрээ" гэж нэрлэж байсан нь үүнтэй холбоотой юм шуу дээ. Тэгэхээр хот айлаас хот үүссэн байж таараа хэмээн өгүүлэв.

Бага сургуулийн 2-р ангийнханд зориулав.




Монголчуудын хот хүрээ гэдэг ойлголт юунаас үүссэн бэ?



Хот сууринд суугчдын өдөр тутмын мөрдөх нэг чухал хууль бол замын хөдөлгөөний дүрэм.



Малчдын ажиллах, амьдрах нөхцөлөөс ургаж гарсан таатай сууц.



Монголчуудын амьдралын гол хэрэглээ идээ шүүс, хоол ундаа цаг хугацаа, ёс горимтой зооглодог тухай.



Хүн төрөлхтөн өдөр тутмын мэдээлэл сонирхон олж авдгийн ачаар амьдрал ахуйгаа хөгжүүлэн зохицуулж, ирээдүйгээ төсөөлдөг.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Хөдөвгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.